




МОНГОЛ УЛСЫН ҮЛДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Автомобильн үлдэсний төв ТӨҮТ 2016 оны жилийн эцсийн
санхүүгийн тайлан



www.audit.mn

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗАР



YAГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

“АВТО ТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараахь хаягаар харилцана уу:

Аудитын тайлан

САГазрын дарга,
тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 263533
Цахим хаяг:
naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням
Утас: 260512
Цахим хаяг:
sambuunyamy@audit.gov.mn

Аудитор: Б.Сэржмядаг
Утас: 260512
Цахим хаяг:
serjmyadagb@audit.gov.mn

Монгол Улсын
Үндэсний аудитын газар:
Засгийн газрын IY байр
Улаанбаатар-46
Бага тойруу 6
Вэб хуудас: www.audit.mn

“Мэдээлэл-Аудит” ХХК
БГД, 17-р хороо,
Амарсанаагийн гудамж
JSD төв, 505, 506 тоот
Захирал: Д.Товуудорж
Утас: 369511
Вэб хуудас: medeeleaudit@gmail.com

АГУУЛГА

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Зорилтот түвшингийн биелэлтийн
мэдээ

Хавсралт 6: “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ-
ын санхүүгийн тайлан, тодруулга



"АВТО ТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ"
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ П.ДЭЛГЭРНАРАН
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audil.gov.mn, http://www.audil.mn

2017.03.15 № 3/465
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

"Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын гүйцэтгэх удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

"Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын санхүүгийн тайлан болон тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, туунд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

АГУУЛГА

1	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	2
2	Байгууллагын хууль, эрх зүйн орчин	2
3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа	3
4	Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн	3
	Дотоод хяналт	4
6	Материаллаг түвшин	4
7	Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаар	4
8	Шилэн дансны мэдээлэл	5
9	Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар	5
10	Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар	5
11	Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар	5
12	Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар	6
13	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
14	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	7
15	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	7
16	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	7
17	Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт	7
19	Товчилсон үгсийн товъёог	8
20	Менежментийн захидал	9-12
21	Аудитлагдсан санхүүгийн тайлан	13-16
22	2016 оны зорилтот түвшин, гүйцэтгэлийн мэдээ	17
23	Сангийн яамтай хийсэн УХӨТ-н тооцоо нийлсэн акт	18
24	Аудитаар залруулсан зөрчлийн баталгаа	19
25	Асуулгын бүртгэл	20
26	"Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын санхүүгийн тайлан, тодруулга	21

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн төрийн аудитын тухай хуулийн 18.5 дугаар зүйлд заасан Үндэсний Аудитын Газрын бүрэн эрхийн хүрээнд "Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд **ҮАГ-САГ/2017/66/СТА-ТӨҮГ** аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

"Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Компанийн удирдлага санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн байгууллагын санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь аудитын байгууллагын үүрэг юм.

"Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 10 дугаар сарын 06-наас 2017 оны 3 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн, "Мэдээлэл Аудит" ХХК-ийн захирал Д.Товуудоржоор удирдуулсан аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

"Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын удирдлага нь Иргэний хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай багц хууль, Татварын тухай багц хууль, Аудитын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон МУ-ын ЗГ-ын 68-р тогтоол "Босго үнэ батлах тухай", "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журам", Сангийн сайдын 2013 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 77 дугаар тушаал "Маягт заавар батлах тухай", "Татварын тайлан гаргах, татварын албанд тайлан хүлээн авах журам", "Татварын өрийн үлдэгдэлд торгууль, алданги тооцох ногдуулах журам", "Сангийн сайдын тушаал журам батлах тухай" 2010 оны 121-р тушаал "Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам" зэрэг хууль эрх зүйн орчны хүрээнд

үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль шинэчлэгдэн мөрдөгдсөнөөс бусад гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

"Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд авто тээврийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохицуулж, зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй байгуулагдсан бөгөөд дараах зорилго зорилтыг тавьж ажилладаг.

Эрхэм зорилго нь: Авто тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын системийг боловсронгуй болгох, техникийн хяналтын үзлэгийн чанарыг сайжруулж, техникийн найдвартай ажиллагаа, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, тээврийн үйлчилгээний соёлыг дээшлүүлэн, зам, тээврийн осол зөрчилгүй ажиллаж, тээврийн хэрэгслийн ашиглалтын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхэд оршино.

Зорилт:

Авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гаргасан бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангахад оршино.

Тус төв нь Улаанбаатар хотод 1 төв салбар, дүүргүүдэд 5 салбар, орон нутагт 22, улсын хэмжээнд нийт 28 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. 2016 оны байдлаар 794 орон тооны үндсэн ажиллагсад ажиллахаар төлөвлөгдсөнөөс, гүйцэтгэлээр үндсэн ажилтан 750, авто тээврийн хэрэгслийн улсын байцаагч 45, гэрээт ажилтан 102, нийт 887 ажиллагсад ажилласан байна.

Сангийн сайдын 2016 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 228 тоот тушаалаар батлагдсан "Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын шинэчилсэн дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.3 "Үйлдвэрийн газрын өмчлөгч нь төр байх бөгөөд төрийн өмчийн төлөөллийг засгийн газраас эрх олгосон төрийн захиргааны байгууллага болох Сангийн яам хэрэгжүүлнэ", 6 дугаар зүйлийн 6.7 "Авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь үйлдвэрийн газрыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1-д "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана. Захирлыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, зохих салбар, хүрээний яамтай зөвшилцөн томилох буюу өөрчилнө" гэж тус тус заасан байна.

"Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд /ТАБ-СТА-А-1/ маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль холбогдох дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглав.

Аудитаар "Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 48-г хийж гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

"Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулахдаа "Ординат" ХХК-ийн бэлтгэсэн UNICUS онлайн програмыг ашигладаг бөгөөд санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэсэн байна.

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус байгууллагын дотоод хяналтын алба нь "Хяналт-Шинжилгээ, үнэлгээ, Дотоод аудитын алба" гэсэн нэртэйгээр, 4 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. 2016 оны тайлант жилд 2015 оны А/185 тоот үйлдвэрийн газрын захирлын тушаалаар батлагдсан "Хяналт-Шинжилгээ, үнэлгээний журам"-ын дагуу дотоод нэгж хэлтсүүдэд үнэлгээ хийх ажлыг голлон хийсэн байна. Дотоод хяналтын ажилтнуудыг сонгохдоо ажлын байрны шаардлагад нийцүүлээгүй байгааг удирдлагад зөвлөж, танилцуулсан.

Материаллагын байдал

Материаллаг түвшинг төлөвлөлтийн үед зардлын хүлээгдэж буй гүйцэтгэл 13 738,4 сая төгрөгийн 1 хувь 137,4 сая төгрөгөөр авсан тул гүйцэтгэлээр нийт зардал 13 605,4 сая төгрөгийн 1 хувь буюу 136,1 сая төгрөг байна. Гүйцэтгэлийн үе шатанд материаллагын түвшинг өөрчлөөгүй болно.

Зорилтот түвшин түүний биелэлтийн талаар

Батлагдсан тайлант оны зорилтот түвшний төлөвлөгөөгөөр 13,793.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэхээр төлөвлөснөөс 13,981.8 сая төгрөгийн орлоготой ажиллаж 101%-иар биелүүлсэн.

Нийт зардлыг 13,738.4 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 99% болох 13,605.4 сая төгрөг зарцуулж, 54.9 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллагаар төлөвлөж 376.4 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Тайлант хугацаанд НДШ, ХХОАТ, бусад татвар, суутгал нийт 3,150.0 сая төгрөг төлөх төлөвлөгөөтэй байснаас 2,666.2 сая төгрөг төлсөн нь 85%-ийн биелэлттэй байна. Энэ нь орон тооны цомхотголтой холбоотой цалингийн зардал буурснаас шалтгаалсан.

Ногдол ашгаар төсөвт төвлөрүүлэхээр 12.4 сая төгрөг төлөвлөснөөс, ТӨБЗГ-ын 2016 оны 1/494 тоот албан бичгийн дагуу 2015 оны цэвэр ашиг 101.5 сая төгрөгийн 20% болох 20.3 сая төгрөг төвлөрүүлж 164%-иар биелүүлжээ.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу дараах хүрээнд мэдээ, мэдээллээ байршуулжээ.

Зорилтот түвшин ба гүйцэтгэл: Зарлагын хэмнэлт, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ, эрх бүхий байгууллагаас баталсан зорилтот түвшин, гүйцэтгэл

Хөрөнгө оруулалт: Хөрөнгийн болон гүйцэтгэлийн зарлага, төсвийн орлого, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн их хэмжээний хэлцлийн талаарх мэдээлэл,

Тендер худалдан авалт: Тендерийн шалгаруулалт, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт,

Бусад: Нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах талаархи мэдэгдлийг зурган хэлбэрээр, батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг жилийн эцсийн байдлаар, Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрүүдийг шилэн дансны цахим сайтад тухай бүрд нь байршуулан ажиллажээ. Холбоос: <https://www.shilendans.gov.mn/org/5158?group=1&year=2016>

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу 7 дансанд 26 уламжлалт, 22 хяналтын эрсдлийг тогтоож нийт батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр 48 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэлээ.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар

Гол онцлог гүйлгээ байхгүй. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

1. Замын-Үүд салбарын бараа материалын дансанд 42.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэсэн.

Шийдвэрлэсэн: Завсрын аудитын явцад залруулсан

2. Замын-Үүд салбарт 14.2 сая төгрөгийн засварын ажилд зарцуулагдсан бараа материал нь данснаас хасагдаагүй нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн

5.1.4-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтлах" гэсэн заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Завсрын аудитын явцад залруулсан

3. Нордикийн сангаас авсан урт хугацаат зээлийн 1,320.1 сая төгрөгийн ханшийн тэгшитгэлийг санхүүгийн тайланд тусгаагүй нь НББОУС 21-ийн 23 дах "гадаад валютын ажил гүйлгээний дараа үеийн хүлээн зөвшөөрөлтийн дагуу "Бүх хөрөнгө, өр төлбөрийг хаалтын ханшаар илэрхийлнэ" гэсэн заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтэстэй тооцоо нийлсэн акт үйлдэж, Валютын ханшийн тэгшитгэл 1,320.1 сая төгрөгийн УХӨТ дансанд тусгаж залруулсан.

4. 2014 онд Төсөвт байгууллагаас ТӨҮГ болон өөрчлөн зохион байгуулагдахдаа Нордикийн сангаас авсан урт хугацаат зээлийн хөрөнгийн эх үүсвэр 5,996.2 сая төгрөгийг салбаруудын санхүүгийн тайланд хувиарлан тусгасан байна. Салбар нь бие даасан хуулийн этгээд биш тул зээлийг төлөх хууль эрх зүйн үндэслэлгүй юм. /Салбар хоорондын дотоод бүртгэлийн асуудал тул нэгтгэсэн санхүүгийн тайланд нөлөөгүй/

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулсан.

5. Санхүүгийн тайланд тайлагнасан НӨАТ-тай борлуулалтын орлого, НӨАТ-ын тайлангаарх борлуулалтын орлого нь 250.2 сая төгрөгийн зөрүүтэй байна. /Татварын тайлантай холбоотой зөрчил бөгөөд нэгтгэсэн санхүүгийн тайланд нөлөөгүй/

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулсан.

6. Худалдан авсан 803.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэхдээ 63.9 сая төгрөгийн НӨАТ-ыг хассан дүнгээр бүртгэсэн нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5-д "үндсэн хөрөнгө бэлтгэхэд зориулж импортоор оруулсан буюу худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн болон үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн албан татварыг хасахгүй" гэсэн заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулсан.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

1. Улсын бүртгэлийн гэрчилгээний өөрийн хөрөнгийн хэмжээнээс Санхүүгийн тайланд тайлагнагдсан хөрөнгийн хэмжээ 8,099.1 сая төгрөгөөр их байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулан тайлагнаж, харин хөрөнгийн өөрчлөлтийг улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгүүлсэний дараа эздийн өмчийн дансанд бүртгэх талаар зөвлөмж өгсөн

2. НБББББ-ийг салбарын бүртгэлийн онцлогыг тусгаагүй, Сангийн сайдын 2012 оны 77 тоот "Маягт заавар батлах тухай" тушаалтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: НБББББ-д салбарынхаа онцлогыг тусгаан, нягтлан бодох бүртгэлдээ хэрэглэж буй програм хангамжтайгаа нийцүүлж шинэчлэн боловсруулж мөрдөх зөвлөмж өгсөн.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

"Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ нь тайлант онд бүтэц орон тоогоо шинэчлэн зохион байгуулсантай холбоотойгоор "Хяналт-Үнэлгээ, Шинжилгээ, Дотоод аудитын алба"-ны дарга нь 2016 оны 11 дүгээр сард шинээр томилогдсон бөгөөд тус алба 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэгдэн байгуулагдсан учраас тус албаны төлөвлөгөөний биелэлт, хийсэн ажлын үр дүнг үнэлж, харьцуулан дүгнэх боломжгүй байсан тул 2017 оны аудитаар Хяналт-Үнэлгээ, Шинжилгээ, Дотоод аудитын албаны үйл ажиллагааг анхаарч авч үзэх шаардлагатай.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

"Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 15,786.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг аудитын явцад 100% залрууулан ажиллалаа.

Үнийн дүнгээр илэрхийлэх боломжгүй НБББББ болон Санхүүгийн тайланд тусгагдсан эздийн өмчийн дүн, улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсан өмчийн дүнгийн зөрүү нь санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөлгүй тул 2016 оны санхүүгийн тайланд залруулан тайлагнасан бөгөөд цаашид улсын бүртгэлийн гэрчилгээнд өмчийн өөрчлөлтөө бүртгүүлэн ажиллах талаар тус тус зөвлөмж өгсөн.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

"Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2015 оны санхүүгийн тайланд аудит хийсэн "Мишээл-Од Аудит" ХХК-иас 3 зөвлөмж өгсөнийг 100 хувь биелүүлж ажилласан байна.

Аудитын санал дүгнэлт

"Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

Товчилсон үгийн тайлал

ҮАГ -Үндэсний аудитын газар

САГ -Санхүүгийн аудитын газар

СТА -Санхүүгийн тайлангийн аудит

СЯ-Сангийн яам

ТӨБЗГ -Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

НБББББ-Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

ГАК -Гэрээт аудитын компани

ТӨҮГ -Төрийн өмчит үйлдэрийн газар

СТОУС – Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт

ОБ - Оршин байгаа

ЭҮ - Эрх ба үүрэг

ТБ - Тохиолдсон байх

ИБ - Иж бүрэн байх

Ү - Үнэлгээ

Х - Хэмжилт

ТИ - Толилуулга ба илчлэл тодруулга

ҮЗ - Үнэн зөв байдал



ҮАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН АГЛАЛ

**“АВТО ТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1

Эздийн өмч

Асуудал 2

НБББББ

2017 оны 3 дугаар сар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг "Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан "Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитын ажиглалт

Улсын бүртгэлийн гэрчилгээний өөрийн хөрөнгийн хэмжээ, Санхүүгийн тайланд тайлагнагдсан хөрөнгийн хэмжээ 8,430.0 сая төгрөгийн зөрүүтэй байна.

Аудитын зөвлөмж

Улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрийн хөрөнгийн өөрчлөлтийг бүртгүүлж, эздийн өмчийн дансанд бүртгэх.

Эрсдэл

Санхүүгийн тайлан мэдээ, мэдээлэл буруу илэрхийлэгдэх. /ЭҮ, ТИ, ҮЗ/

Хууль, дүрэм, журам зөрчигдөх /ЭҮ, ТБ, Ү/

Үйлчлүүлэгчийн хариу

2017 онд зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

Аудитын ажиглалт

НБББББ-д салбарын бүртгэлийн онцлогыг тусгаагүй, Сангийн сайдын 2012 оны 77 тоот "Маягт заавар батлах тухай" тушаалтай нийцэхгүй байна

Аудитын зөвлөмж

НБББББ-т салбарынхаа онцлогыг тусган, нягтлан бодох бүртгэлдээ хэрэглэж буй програм хангамжтайгаа нийцүүлж шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах.

Эрсдэл

Санхүү бүртгэлийн үйл ажиллагаа доголдох /ЭҮ, ТИ, ҮЗ/

Хууль зөрчигдөх /ЭҮ, ТБ/

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Байгууллагын тайлан		Аудитын запруулга	Аудит хийгдсэн жилийн эцсийн үзүүлэлт
	Жилийн эхэнд	Жилийн эцэст		
ХӨРӨНГӨ				
Эргэлтийн хөрөнгө				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1 726 142 629	1 518 391 171		1 518 391 171
Дансны авлага	20 429 904	5 205 955		5 205 955
Татвар, НДШ-н авлага	128 343			-
Бусад авлага	49 077 147	55 879 882		55 879 882
Бусад санхүүгийн хөрөнгө				-
Бараа материал	1 194 897 708	1 328 689 714		1 328 689 714
Урьдчилж төлсөн зардал/гооцоо	53 228 498	673 522 104		673 522 104
Бусад эргэлтийн хөрөнгө	15 632 000	14 585 000		14 585 000
Эргэлтийн хөрөнгийн дүн	3 059 536 227	3 596 273 826	-	3 596 273 826
Эргэлтийн бус хөрөнгө				
Үндсэн хөрөнгө	14 742 333 198	14 959 632 576	63 873 329	15 023 505 904
Биет бус хөрөнгө	178 075 224	234 707 279		234 707 279
Биологийн хөрөнгө				
Урт хугацаат хөрөнгө оруулалт				
Бусад эргэлтийн бус хөрөнгө				
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	14 920 408 422	15 194 339 855	63 873 329	15 258 213 184
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	17 979 944 649	18 790 613 681	63 873 329	18 854 487 009
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ				
Өр төлбөр				
Богино хугацаат өр төлбөр				
Дансны өглөг	119 658 082	154 554 739		154 554 739
Цалингийн өглөг		6 131 350		6 131 350
Татварын өр	79 865 534	157 233 409	63 873 329	221 106 738
НДШ-н өглөг	5 673	6 850 416		6 850 416
Богино хугацаат зээл				
Хүүний өглөг				
Ногодол ашгийн өглөг				
Урьдчилж орсон орлого	6 292 046	49 705 533		49 705 533
Нөөц /өр төлбөр/				
Богино хугацаат өр төлбөр				
Богино хугацаат өр төлбөрийн дүн	205 819 315	374 475 448	63 873 329	438 348 776
Урт хугацаат өр төлбөр				
Урт хугацаат зээл	6 505 762 291	6 505 762 291	1 320 079 455	7 825 841 746
Нөөц /өр төлбөр/				
Урт хугацаат өр төлбөрийн дүн	6 505 762 291	6 505 762 291	1 320 079 455	7 825 841 746
Өр төлбөрийн нийт дүн	6 711 581 606	6 880 237 738	1 383 952 784	8 264 190 523
Эздийн өмч				
Өмч : - төрийн	8 340 902 952	8 340 902 952	(8 099 082 952)	241 840 000
- хувийн				
- хувьцаат				
Халаасны хувьцаа				
Нэмж төлөгдсөн капитал				
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	134 585 950	134 585 950		134 585 950
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц				
Эздийн өмчийн бусад хэсэг	3 504 103 118	3 860 425 363	8 099 062 952	11 959 488 314
Хуримтлагдсан ашиг	(711 228 974)	(425 538 322)	(1 320 079 455)	(1 745 617 778)
Эздийн өмчийн дүн	11 268 383 043	11 910 375 942	(1 320 079 455)	10 690 296 487
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	17 979 944 649	18 790 613 681	63 873 329	18 854 487 009

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Байгууллагын тайлан		Аудитын заглуулга	Аудит хийгдсэн жилийн эцсийн үзүүлэлт
	Жилийн эхэнд	Жилийн эцэст		
Борлуулалтын орлого (цэвэр)	11 324 911 948	9 811 391 285		9 811 391 285
Борлуулалтын өртөг	10 547 403 756	11 826 837 972		11 826 837 972
Нийт ашиг (алдагдал)	777 508 193	(2 015 446 688)	-	(2 015 446 688)
Түрээсийн орлого	94 047 069	95 017 621		95 017 621
Хүүний орлого	205 926 977	98 136 172		98 136 172
Ногдол ашгийн орлого		4 012 727		4 012 727
Эрхийн шимтгэлийн орлого		3 973 238 386		3 973 238 386
Бусад орлого	646 507 267			
Борлуулалт, маркетингийн зардал		135 939 513		135 939 513
Ерөнхий ба удирдлагын зардал	973 282 903	1 130 696 805		1 130 696 805
Санхүүгийн зардал				
Бусад зардал				
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(87 613 960)	41 223	(1 320 079 455)	(1 320 038 233)
Үндсэн хөрөнгө данснаас хаассаны олз (гарз)		500 000		500 000
Биет бус хөрөнгө данснаас хаассаны олз (гарз)				
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)				
Бусад ашиг (алдагдал)	(486 455 524)	(511 901 817)		(511 901 817)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	176 657 119	378 961 306	(1 320 079 455)	(943 118 149)
Орлогын татварын зардал	75 072 660	88 932 190		
Татварын дараах ашиг (алдагдал)	101 584 459	288 029 116	(1 320 079 455)	(943 118 149)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)				
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	101 584 459	288 029 116	(1 320 079 455)	(943 118 149)
Бусад дэлгэрэнгүй орлого				
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Бусад олз (гарз)				
Цэвэр ашиг (алдагдал)	101 584 459	288 029 116	(1 320 079 455)	(943 118 149)
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)				

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2014 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	7 858 130 108	135 633 600	3 504 103 118	79 402 731	11 577 359 556
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(13 056 184)	(13 056 184)
3	Залруулсан үлдэгдэл	7 858 130 108	135 633 600	3 504 103 118	86 438 567	11 584 303 391
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				101 584 459	101 584 459
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт	482 772 844				482 772 844
7	Зарласан ногдол ашиг				(879 250 000)	(879 250 000)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(1 047 650)		(200 325)	(1 247 975)
9	2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	8 340 902 952	134 585 950	3 504 103 118	(711 429 299)	11 268 162 710
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(2 138 139)	(2 138 139)
11	Залруулсан үлдэгдэл	8 340 902 952	134 585 950	3 504 103 118	(713 567 438)	11 268 024 579
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(1 032 050 339)	(1 032 050 339)
13	Бусад дэлгэрэнгүй орлого					-
14	Өмчид гарсан өөрчлөлт			358 322 247		358 322 247
15	Зарласан ногдол ашиг					-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
	Аудитаар залруулсан өөрчлөлт	(8 099 062 952)		8 099 062 952		
17	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	241 840 000	134 585 950	11 950 488 314	(1 745 617 778)	10 590 298 487

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Жилийн эхэнд	Жилийн эцэст
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	32 065 582 752	33 935 223 058
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	11 667 362 633	14 812 780 322
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	450 255	8 931 135
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого	20 377 769 864	19 113 511 601
Мөнгөн зарлагын дүн (-)	32 224 634 091	33 392 055 274
Ажиллагчдад төлсөн	7 082 973 885	8 353 303 911
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1 142 358 962	1 143 097 238
Бараа материал худалдан авахад төлсөн	632 749 789	398 402 757
Ашиглалтын зардалд төлсөн	627 579 029	678 421 801
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	243 939 992	227 933 623
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	800 087 288	892 638 617
Даатгалын төлбөрт төлсөн	5 941 861	51 439 440
Бусад мөнгөн зарлага	21 689 003 284	21 648 817 888
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(159 051 339)	543 167 784
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	214 841 977	98 136 172
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	8 915 000	
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүгийн орлого	205 926 977	98 136 172
Хүлээн авсан ногдол ашиг		
Мөнгөн зарлагын дүн (-)	560 002 030	849 055 414
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	431 420 389	701 370 976
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	128 581 631	147 684 438
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(345 160 053)	(750 919 242)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	68 533	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандив		
Бусад	68 533	
Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
Санхүүгийн түрээсийн өглөлт төлсөн		
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	68 533	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(504 142 859)	(207 751 458)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2 230 285 488	1 726 142 629
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1 726 142 629	1 518 391 171

2016 ОНЫ ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭ

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 он		Зөрүү	Биелэлтийн хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт орлого	/мян.төг/	13 793 342	13 981 796	(188 454)	101%
	Техникийн хяналт, оношлогоо	/мян.төг/	5 485 000	5 514 823	(29 823)	101%
	Зорчигч тээврийн тэндрийн шимтгэл	/млн.төг/	7 522 500	7 283 625	238 875	97%
	Бүртгэл, бусад	/мян.төг/	785 842	1 183 348	(397 506)	151%
2	Нийт зардал	/млн.төг/	13 738 391	13 605 376	133 015	99%
3	Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	/мян.төг/	54 951	376 420	(321 469)	685%
4	Орлогын татвар	/мян.төг/	5 495	88 932	(83 437)	1618%
	Цэвэр ашиг, алдагдал	/млн.төг/	49 456	287 488	(238 032)	581%
5	Төсвийн төлбөрт	/мян.төг/	3 150 000	2 666 160	483 840	85%
6	Нийт авлага	/мян.төг/	80 000	61 086	18 914	76%
7	Нийт өглөг	/мян.төг/	6 571 582	8 264 191	(1 692 609)	128%
8	Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал	/төгрөг/	1.00	1.03	(0.03)	102%
9	Ногдол ашиг	/мян.төг/	12 364	20 317	(7 953)	164%
	Хөрөнгө оруулалт	/млн.төг/	1 620 575	1 525 575	95 000	94%